



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Чингэлтэй, Хан-Уул дүүргийн дулааны шугам хоолойг шинэчлэн солих ажлын хүрээнд бий болсон нийт 886,304,195.00 (найман зуун наян зургаан сая гурван зуун дөрвөн мянга нэг зуун ерэн таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Бямба-Очир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001531

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 03 -ны өдрийн
0.4 дугаар тогтоолын хавсралт



**"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал			Ашиглалтад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Хөрөнгө оруулсан компани
		хэмжих нэгж	биет хэмжээ	тоо хэмжээ			
1	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг орчмын халаалтын зуухаар хангагддаг барилгуудыг төвлөрсөн дулаанд холбох шугам	хос метр	ф300	105	2017	418,491,125.00	"М-Си-Эс проперти" ХХК, "Жи Жи Би" ХХК, "Чинбулаг" ХХК, "Эх ногоон дэлхий" ХХК
		хос метр	ф250	440	2017		
		хос метр	ф150	455	2017		
2	6-р магистраль Тк621-ийн салаа, хагас нэвтрэх сувагтай дулааны шугам	хос метр	ф273	128.5	2012	258,874,896.00	"Макс өргөө" ХХК
3	6-р магистраль Тк621-ийн Тэнгис кинотеатрын салаа, хагас нэвтрэх сувагтай дулааны шугам	хос метр	ф150	148	2017	208,938,174.00	Иргэн К.Пүрэв
		хос метр	ф300	20	2017		
	Нийт дүн			1296.5		886,304,195.00 (найман зуун наян зургаан сая гурван зуун дөрвөн мянга нэг зуун ерэн таван)	